



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/630

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV дугаар Хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 25/05 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгуулагдах өсвөрийн шатарчдын 21 аймгийн багийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлсүгэй.
2. 21 аймгийн багийн аваргын тэмцээнд оролцоход шаардлагатай 1.000.000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010874